



**НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ЭМЧ, АЖИЛЛАГСДЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЖ,
ҮР ДҮНГИЙН УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Зорилго

Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх, үр бүтээлтэй, идэвхи санаачлагатай, хариуцлагатай ажиллах хөшүүрэг бий болгох тэдний ажлын гүйцэтгэлийн үр дүнг ил тод бодитойгоор үнэн зөв үнэлж дүгнэхэд оршино.

Хоёр. Үндэслэл

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.4 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.5 дах заалт, Засгийн газрын 2012 оны 150 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

Гурав. Хамрах хүрээ

Байгууллагын эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, үйлчлэгч, ажиллагсад

Дөрөв. Дүгнэх журам

4.1 Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг батлагдсан аргачлалын дагуу тухайн тасаг нэгжийн эрхлэгч нар сараар нэгтгэн үнэлгээг ажилтан тус бүрд танилцуулан гарын үсэг зуруулж дараа сарын эхний 7 хоногт багтаан хүний нөөцийн албанд ирүүлнэ.

4.2 Тасаг, нэгжээс ирсэн ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг Удирдлагын зөвлөл улирлаар нэгтгэн хэлэлцэж олгоно.

4.3. Ажилтнуудынхаа ажлын гүйцэтгэлийг үнэлэх хугацааны мөчлөгийг сар дотроо хэрхэн тогтоох асуудлыг тасгийн эрхлэгч нар дотооддоо шийдвэрлэнэ.

4.4 Удирдлагын зөвлөлийн хурлаар гаргасан дүгнэлтийг үндэслэн мөнгөн урамшууллыг олгох шийдвэрийг байгууллагын дарга гаргана.

4.5 Засгийн газрын 2012 оны 150 дугаар тогтоолын дагуу ажлын үр дүнгийн үнэлгээнээс хамааран дараах хувь хэмжээгээр урамшууллыг тооцож олгоно.

Шалгуурын биелэлтийн хувь буюу ажлын гүйцэтгэл	71-76%	77-79%	80-82%	83-85%	86-89%	90-91%	92-93%	94-95%	96-97%	98-100%
Албан тушаалын үндсэн цалингаас урамшуулал тооцох хувь / сараар/	6%	7%	8%	9%	10%	11%	12%	13%	14%	15%

4.6 Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хугацаа хоцорч ирүүлсэн материалыг хүлээж авахгүй. Тухайн тасгийн эрхлэгчийн ажлын үр дүнгийн шалгуурт оруулж тооцно.

4.7 Дараах тохиолдолд тухайн сарын урамшууллыг олгохгүй, тухайн алдаа зөрчлийн цар хүрээнээс хамааран улирлын урамшуулалд нөлөөлөх эсэхийг Удирдлагын зөвлөлөөр шийдвэрлэнэ. Үүнд:

4.7.1 Авилга, ашиг сонирхлын зөрчил гаргасан

4.7.2 Мэргэжлийн алдаа, зөрчил бүртгэгдсэн

4.7.3 Үндсэн үүргээ биелүүлээгүй /санаатай болон санамсаргүй/

4.7.4 Байгууллагын нэр хүндийг унагаасан

4.7.5 Ээлжийн амралтаа биеэр эдэлсэн болон өвчтэй, чөлөөтэй хугацаа тухайн сарын фонд өдрийн 50 хувиас дээш тохиолдолд энэхүү Үр дүнгийн урамшуулалд хамаарахгүй.

4.8 Мэргэжлийн онцгой үр чадвар гаргасан болон шинэлэг бүтээлч санааг эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлсэн, олон улсын чанартай уралдаан тэмцээн, урлаг спортын наадамд идэвхитэй оролцсож байгууллагын нэрийг гаргасан тохиолдолд үр чадварын нэмэгдлийг 15%-иар тооцож олгоно.

4.9 Өөрийн мэдлэг мэргэжлээ дээшлүүлэн, цаг зав зарцуулан судалгааны ажил хийж онол практикийн хуралд илтгэл тавьсан тохиолдолд үр чадварын нэмэгдлийг 15%-иар тооцож олгоно.

4.10 Төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байгууллагын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлсэн тохиолдолд дараах байдлаар үр чадварын нэмэгдлийг нэмэгдүүлж олгоно. Үүнд:

- 1 сая хүртэлх төгрөгний- 5%
- 1-10 сая төгрөгний -10%
- 10 саяас дээш төгрөгний -15%

Тав. Ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт, оноо

5.1 Сарын ажлын гүйцэтгэл, үр дүнг нийтэд нь 100 оноогоор тооцно. Үүнд:

5.1.1 Үндсэн шалгуур үзүүлэлт:

- **Ажлын ачаалал, хариуцлага - 20 оноо**
 - Ажлын цаг ашиглалт-5 оноо
 - АШБүртгэл хөтлөлт, мэдээ, тайланг хугацаанд нь өгсөн байдал-5 оноо
 - Ажлын ачаалал-5 оноо
 - Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт-5 оноо
- **Үйлчилгээний чанар - 25 оноо**
 - Хүлээгдэл, чирэгдэлгүй ажилласан байдал-5 оноо
 - Ёс зүй, харьцаа, хандлагын байдал-15 оноо
 - Үйлчлүүлэгч, хамт олны сэтгэл ханамжийн байдал-5 оноо
- **Эмнэлгийн тусламж үйлчилгээнд оруулсан хувь, нэмэр-25 оноо**
 - Эмчилгээ үйлчилгээнд шинэ бүтээл, оновчтой санааг нэвтрүүлэн, эдийн засгийн үр өгөөжийг тооцсон байдал-5 оноо
 - Ажлын идэвхи, олон нийтийн арга хэмжээнд оролцсон байдал-5 оноо
 - Судалгааны ажил хийж, онол практикийн хуралд илтгэл тавьсан эсэх-15 оноо

